

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2019 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2 . Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	5
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	8
2.12. Шилэн дансны мэдээлэл	8
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	9
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	9
3. Менежментийн захидал	10
4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан	13
4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	13
4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	15
4.3. Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	17
4.4. Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	20
4.5. Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	21
4.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан.....	24
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	25

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

СЭТГЭЦИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН
ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЗАХИРАЛ
Л.НАРАНЦЭНГЭЛ ТАНАА

2020.08.27 № 06/634
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 . Аудитын тайлан

2.1. Оршил

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн ерөнхий захирал Л.Насанцэнгэл Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй, болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 25-наас 2020 оны 2 дугаар сарын 14-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 21-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Үндэсний аудитын газрын захиалгаар “Уваа уул аудит” ХХК-ийн захирал Ч.Мөнхтуяа, чанарын хяналтын менежер А.Оюун, аудитор Б.Буяндэлгэр, туслах аудитор Э.Номинчулуун хариуцаж хэрэгжүүлэв.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2020 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 5/88 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь “Монголын нийт хүн амд сэтгэцийн эрүүл мэндийн төрөлжсөн мэргэжлийн тусламж үйлчилгээг чанартай тэгш хүртээмжтэй үзүүлэн, анхан болон үндсэн мэргэжлийн тусламжийг мэргэжил арга зүйгээр хангахад” оршино.

Монгол Улсын Сэтгэцийн эрүүл мэндийн тухай хуулийг хэрэгжүүлэх зорилгоор Эрүүл мэндийн сайдын 2006 оны 331 тоот тушаалаар Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Анхан болон хоёр дахь шатлалын тусламжийг мэргэжил арга зүйгээр хангах;
- Сэтгэцийн эмгэгээс урьдчилан сэргийлэх, оношлох, эмчлэх, нөхөн сэргээх;
- Гурав дахь шатлалын тусламж үйлчилгээг чанартай тэгш хүртээмжтэй хүргэх;
- Архидан согтуурах, мансуурах, тоглоомд донтох, стресст өртөх зэрэг сэтгэцийн эрүүл мэндэд нөлөөлөх нийгэм орчны сөрөг хүчин зүйлсээс сэргийлэх;
- Эрдэм шинжилгээ статистик, тандалт судалгаа, мэдээллийн сүлжээ, гадаад харилцааг хөгжүүлэх;

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын 2018 оны 80 дугаар тогтоол “Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай
- Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 301 дүгээр тушаал “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол “Журам шинэчлэн батлах тухай”
- Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн дотоод журам

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус төвийн одоо мөрдөж байгаа 2017 онд баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох” ХХК-ийн “Acolous”, цалин хөлсний “Payroll” программ хангамж ашигладаг байна.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 11 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 3 дугаар улирлын Санхүүгийн үр дүнгийн тайланг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 8,907,397.6 мянган төгрөгөөс тооцон 89,073.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны 4 дүгээр улирлын Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаас 125,264.3 мянган төгрөгөөр тооцсон нь эрсдэлийн түвшинг “дунд” гэж үзсэнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгө дансанд хөрөнгө оруулалтаар 356,510.4 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан 174,869.1 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн. Үнэ төлбөргүй шилжүүлсэн 48,470.0 мянган төгрөг, акталсан 30,774.0 мянган төгрөгийн хөрөнгөөр хасагдсан байна.

Нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 911,116.2 мянган төгрөгөөр буюу 5.1 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

	/мянган төгрөг/		
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	3,320.00	-	(3,320.00)
Авлага	69,875.75	-	(69,875.75)
Урьдчилгаа	79,070.00	31,917.33	(47,152.68)
Бараа материал	654,610.14	676,406.53	21,796.39
Үндсэн хөрөнгө	17,028,246.97	16,215,682.85	(812,564.12)
Нийт хөрөнгө	17,835,122.86	16,924,006.70	(911,116.16)
Өр төлбөр			-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	17,835,122.86	16,924,006.70	(911,116.16)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	17,835,122.86	16,924,006.70	(911,116.16)

Авлага дансны үлдэгдэл буурсан нь өмнөх онд нэмэлт санхүүжилтийн данснаас татуулсан 58,955.7 мянган төгрөг, хувь хүмүүсээс авах авлага 10,920.0 мянган төгрөгийг тооцоог бүрэн дуусвар болгосон.

Урьдчилж гарсан зардал данс буурсан нь 2018 онд “Сэтгэцийн эмгэг, архидан донтох өвчлөлөөс урьдчилан сэргийлэх” зорилгоор телевиз, радио, олон нийтийн мэдээллийн хэрэгслээр сурталчилгаа явуулах гэрээ байгуулж уг үйл ажиллагааг тайлант онд бүрэн хэрэгжүүлсэн байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь түлш, шатах тослох материал дансанд 67,715.9 мянган төгрөгийн нүүрсний үлдэгдэлтэй байгаа нь байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах 1 сарын хэрэглээг нөөцөлсөн.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь тайлант үеийн элэгдэл, хорогдлын зардлаас тус тус шалтгаалсан байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв тайлант онд 501,000.0 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлого төвлөрүүлэхээр баталсан, гүйцэтгэлээр 620,752.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 23.9 хувиар давуулан биелүүлсэн байна.

Төлбөртэй үйлчилгээний орлого 119,752.5 мянган төгрөгөөр давсан нь хэвтэн эмчлүүлэгсдийн тоо өссөнөөс шалтгаалсан байна. Давсан орлогоос 109,456.2 мянган төгрөгийг зарцуулж 10,296.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Тайлант онд төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрт зориулан 11,059,345.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 11,059,345.9 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 10,558,345.9 мянган төгрөгийг улсын төсвөөс, 501,000.0 мянган төгрөгийг үндсэн болон туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлыг зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 11,054,355.8 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь эм бэлдмэл эмнэлгийн хэрэгслээс 2,555.3 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээнээс 1,792.6 мянган төгрөг зарцуулагдаагүй үлдсэнээс шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: Гадаад төсөл хөтөлбөрөөс 116,077.5 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 195,461.0, мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 109,456.2 мянга, нийт 420,994.7 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалингийн зардалд 50,997.6 мянга, хангамж, бараа материалын зардалд 41,556.4 мянга, нормативд зардалд 21,450.0 мянга, эд хогшил худалдан авах зардалд 100,036.3 мянга, томилолт зочны зардалд 67,359.8 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 117,829.6 мянга, бусад урсгал шилжүүлгийн зардалд 11,025.0 мянга, нийт 410,254.7 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 10,740.0 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 11 эрсдэл, гүйцэтгэх үе шатанд 10 эрсдэл нэмж тодорхойлж нийт 21 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 1,739,874.2 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 442,349.4 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,644.7 мянган төгрөгийн зөрчилд 2 акт тогтоож, 34,659.9 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 1,259,220.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгч байна.

1. Төлбөртэй үйлчилгээний орлогоос 1,500.0 мянган төгрөгийн зарлага гарган төсөвт төвлөрүүлээгүй нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 2.6 “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн касстаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана” гэсэн заалттай нийцэхгүй, “үнэн зөв байх”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох эздээр нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

2. Нэр бүхий хүний 2,144.7 мянган төгрөгийн урамшуулал илүү олгосон нь Захиргааны ерөнхий хуулийн 47.3 “Захиргааны актын аль нэг хэсэг илт хууль бус бөгөөд тэр нь тухайн захиргааны актыг гаргах гол үндэслэл болж байгаа бол захиргааны акт бүхэлдээ илт хууль бус байна” гэсэн заалттай нийцэхгүй, “үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, холбогдох эздээр нөхөн төлүүлэхээр төлбөрийн акт тогтоосон.

3. Шатахууныг норм лимитээр тооцож олгоогүйгээс 1,033.5 мянган төгрөг илүү, 421.5 мянган төгрөгийг дутуу олгосон. Албан үүргээ гүйцэтгэхэд зориулсан таксины мөнгө гэж 5,683.0 мянган төгрөгийн шатахуун талон олгосон нь Монгол Улсын Дэд бүтцийн сайдын 2004 оны 19 дүгээр тушаал, Төсвийн тухай хуулийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй, “үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөв.

4. Төлбөртэй үйлчилгээний орлогоос 3,699. 0 мянган төгрөгийн зарлага гарган бараа материал худалдан авсан нь Сангийн сайдын 2012 оны 276 дугаар тушаалын 2.6 “Төсвийн байгууллага үндсэн болон туслах үйл ажиллагаа (бусад орлого)-наас орох орлогыг мөнгөн кассатаа бэлнээр хүлээн авч энэхүү орлогыг / түүнийг шууд захиран зарцуулах эрхгүй / ажлын дараагийн өдөрт багтаан кассын нярав Төрийн сан дахь бүртгэлийн дансанд тушаана” гэсэн заалттай нийцэхгүй, “оршин байх”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөв.

5. Байгууллагын бүтэц орон тоонд батлагдаагүй барилгын засварын ажилтан авч Төрийн үйлчилгээний шатлал зэрэглэлээр цалинжуулж 23,822.9 мянган төгрөгийн цалин олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1. “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;” Засгийн газрын 2003 оны 233 дугаар “Төсвийн байгууллагын зарим ажил, үйлчилгээг гэрээгээр гүйцэтгүүлэхэд баримтлах чиглэл” тогтоолын 3.5 дахь заалт, гэсэн заалттай нийцэхгүй, “үнэн зөв байх”, “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх талаар албан шаардлага өгөв.

Аудитаар илэрсэн 1,259,220.5 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, бусад төсөл хөтөлбөрөөс олгосон санхүүжилтийн хэрэгжилт, түүний зардлыг хянах, байгууллагын бүтэц орон тоо, төсвийн үндсэн үйл ажиллагааны орлогын төлөвлөлтөд анхаарал хандуулах чухал гэж үзсэн.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 144 мэдээллийг хугацаанд нь, 1 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 175,841.3 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоосноос 22,646.9 мянган төгрөгийг барагдуулсан, 97,097.1 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Нийт 3 зөвлөмж өгснөөс 2 зөвлөмж хэрэгжих шатанд, 1 зөвлөмжийг хэрэгжүүлээгүй буюу зөвлөмжийн хэрэгжилт 66.6 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Зардлын данстай холбоотой асуудал

1.1 Илрүүлэлт:

Нийт ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэж дэмжлэг үзүүлэх үүднээс ажилчдын ажилласан жил ур чадвар, олон нийтийн арга хэмжээнд идэвх санаачилга гарган ажилласан байдлыг харгалзан 40.0-110.0 мянган төгрөгийн урамшуулалд 51,030.0 мянган төгрөг олгосон нь Төсвийн тухай хуулийн 6.4.1 “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэсэн заалттай нийцэхгүй, “үнэн зөв байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

1.2 Эрсдэл:

Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулаагүй, Төсвийн тухай хууль зөрчих, батлагдсан төсөв хэтрэх.

1.3 Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, гэрээний үүргээ биелүүлж ажиллах талаар зөвлөмж өгөв.

1.4 Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 5/162 тоот албан бичгээр алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

2 Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 1,204,768.8 мянган төгрөгийн хөрөнгө байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор “ Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” гэсэн заалттай нийцэхгүй, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

2.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан үнэн бодитой илэрхийлэгдэхгүй байх, хөрөнгийн ашиглалт алдагдах.

2.3. Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг гаргахгүй байх, хөрөнгийн ашиглагдах жил, үнийг шинэчлэн тогтоох.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 5/162 тоот албан бичгээр алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

3 Худалдан авалт болон гэрээний биелэлт, хэрэгжилттэй холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

Эм эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх гэрээний нийт дүнгээс 614.3 мянган төгрөгийн илүү худалдан авалт хийсэн.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6 “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах” гэсэн заалттай нийцэхгүй, “Иж бүрэн байх”, “Үнэн зөв ба үнэлгээ” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2. Эрсдэл:

Батлагдсан төсөв хэтрэх, гэрээний үүргээ зөрчих.

3.3. Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, гэрээний үүргээ биелүүлж ажиллах талаар зөвлөмж өгөв.

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 5/162 тоот албан бичгээр алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн

4 Төсвийн өмнө хүлээсэн үүргийн биелэлттэй холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Албан хэрэгцээний hyundai tucson 2.0 маркийн автомашинд 2,807.4 мянган төгрөгийн шатахуун илүү олгосон.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2015 оны 184 дугаар "Суудлын автомашины ашиглалтын талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 2 дахь заалттай нийцэхгүй, “Үнэн зөв ба үнэлгээ” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

4.2. Эрсдэл:

Батлагдсан төсөв хэтрэх, төсвийг үр ашиггүй зарцуулах

4.3. Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, шатахууны тооцоог холбогдох журам зааврын дагуу бодож олгох.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

САГ-2020/129/СТА-ТШЗ

Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төвийн 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн 5/162 тоот албан бичгээр алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийгдсэн санхүүгийн тайлан

4.1. Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>806,875,891.55</u>	<u>708,323,856.73</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3,320,000.00	00.00
311	Кассанд байгаа бэлэн мөнгө	3,320,000.00	00.00
31110	Төгрөг	3,320,000.00	00.00
33	АВЛАГА	69,875,750.00	00.00
33300	Татаас, санхүүжилтийн авлага	58,955,750.00	00.00
335	Бусад авлага	10,920,000.00	00.00
3352	Хувь хүмүүсээс авах авлага	10,920,000.00	00.00
34	УРЬДЧИЛГАА	79,070,000.00	31,917,325.00
34600	Урьдчилж гарсан зардал	79,070,000.00	31,917,325.00
35	БАРАА МАТЕРИАЛ	654,610,141.55	676,406,531.73
351	Түүхий эд материал	221,472,005.59	194,446,523.41
35110	Тусгай зориулалттай материал	38,475,876.97	24,991,689.52
35130	Эм боох материал	182,996,128.62	169,454,833.89
354	Хангамжийн материал	116,360,094.60	140,826,472.40
35410	Бичиг хэргийн материал	7,558,634.00	6,339,710.00
35420	Аж ахуйн материал	29,005,485.60	28,610,510.00
35440	Түлш, шатах тослох материал	13,266,575.00	67,715,910.00
35450	Барилгын засварын материал	10,691,200.00	10,253,640.00
35460	Хүнсний материал	38,093,955.00	16,905,275.00
35470	Улсын мэдээллийн маягт	17,744,245.00	11,001,427.40
35500	Бусад хангамжийн материал	316,778,041.36	341,133,535.92
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>17,028,246,970.51</u>	<u>16,215,682,848.27</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	17,028,246,970.51	16,215,682,848.27
392	Биет хөрөнгө	16,132,400,254.07	15,300,960,506.73
39201	Барилга, байгууламж, орон сууц	13,695,207,565.82	14,156,188,566.82
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-425,727,677.88
39203	Авто-тээврийн хэрэгсэл	169,986,000.00	169,986,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-119,784,611.06	-139,826,277.74
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	3,665,744,069.54	3,610,057,669.54
39206	Хуримтлагдсан элэгдэл	-2,195,730,851.44	-2,726,543,042.15
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,607,497,123.03	1,626,363,866.61
39208	Хуримтлагдсан элэгдэл	-790,320,015.27	-1,059,890,119.86
39209	Зам, гүүрийн байгууламж	8,994,148.00	9,623,348.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-557,267.40	-2,038,948.40
39214	Бусад үндсэн хөрөнгө	65,626,248.00	70,471,248.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-33,704,113.15	-47,146,084.21
39217	Ном	59,441,958.00	59,441,958.00
393	Биет бус хөрөнгө	895,846,716.44	914,722,341.54
39301	Програм хангамж	40,595,000.00	63,095,000.00

39302	Хуримтлагдсан элэгдэл	-32,052,083.56	-35,676,458.46
39303	Бусад биет бус хөрөнгө	887,303,800.00	887,303,800.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>17,835,122,862.06</u>	<u>16,924,006,705.00</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>00.00</u>	<u>00.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>17,835,122,862.06</u>	<u>16,924,006,705.00</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	17,835,122,862.06	16,924,006,705.00
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	7,876,381,555.29	7,876,381,555.29
51101	Өмч: - төрийн	7,876,381,555.29	7,876,381,555.29
512	Хуримтлагдсан үр дүн	465,819,129.53	-445,297,027.53
51210	Өмнөх үеийн үр дүн	465,819,129.53	465,819,129.53
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-911,116,157.06
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	00.00	00.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9,492,922,177.24	9,492,922,177.24
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV	<u>17,835,122,862.06</u>	<u>16,924,006,705.00</u>

4.2. Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	10,405,078,587.00	11,603,806,995.96
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	664,442,812.30	694,162,173.96
120	Нийтлэг татварын бус орлого	490,290,133.30	523,050,979.96
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	490,290,133.30	523,050,979.96
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	490,290,133.30	512,804,064.56
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	10,246,915.40
120009	Бусад орлого	00.00	00.00
122	Тусламжийн орлого	174,152,679.00	171,111,194.00
122001	Хандив тусламж /дотоод/	174,152,679.00	171,111,194.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	9,740,635,774.70	10,909,644,822.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	9,235,790,900.00	10,558,345,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	9,235,790,900.00	10,558,345,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	504,844,874.70	351,298,922.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	118,590,160.00	105,337,540.00
131102	Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл	00.00	136,505,200.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	159,028,550.00	109,456,182.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	227,226,164.70	171,111,194.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	11,078,310,732.27	12,526,438,153.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	11,078,310,732.27	12,526,438,153.02
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	10,826,839,848.93	12,213,240,974.02
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	6,022,877,220.05	6,691,561,568.91
210101	Үндсэн цалин	6,011,832,503.05	6,689,759,410.91
210104	Урамшуулал	11,044,717.00	1,802,158.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	719,941,618.96	836,283,413.65
210201	Тэтгэврийн даатгал	482,859,567.31	567,962,902.32
210202	Тэтгэмжийн даатгал	60,231,630.08	66,819,164.98
210203	ҮОМШӨ-ний даатгал	48,666,230.18	53,068,773.98
210204	Ажилгүйдлийн даатгал	11,488,244.01	12,811,383.20
210205	Эрүүл мэндийн даатгал	116,695,947.38	135,621,189.17
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	607,142,157.20	623,505,783.40
210301	Гэрэл, цахилгаан	147,213,732.20	162,842,118.40
210302	Түлш, халаалт	424,830,025.00	420,235,665.00
210303	Цэвэр, бохир ус	35,098,400.00	40,428,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	205,663,893.67	217,526,311.75
210401	Бичиг хэрэг	26,330,096.00	28,920,460.00
210402	Тээвэр, шатахуун	31,985,900.00	48,847,900.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,914,000.00	8,400,030.40

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	119,543,900.00	116,990,168.35
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,889,997.67	14,367,753.00
2105	Нормативт зардал	1,655,101,018.23	1,879,105,725.51
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	872,863,048.83	1,014,256,666.78
210502	Хоол, хүнс	751,027,195.00	805,989,580.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	31,210,774.40	58,859,478.73
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	115,044,940.00	218,944,412.96
210601	Багаж, техник, хэрэгсэл	14,346,500.00	21,788,363.96
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	5,987,300.00	4,707,440.00
210604	Урсгал засвар	94,711,140.00	192,448,609.00
2107	Томилолт, зочны зардал	3,882,400.00	71,242,150.00
210701	Гадаад албан томилолт	00.00	13,955,750.00
210702	Дотоод албан томилолт	3,882,400.00	57,286,400.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	55,610,732.55	167,615,358.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,000,000.00	103,866,975.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	7,500,000.00	7,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,244,405.00	941,112.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	462,700.00	319,600.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	88,000.00	88,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	10,084,160.00	14,553,800.00
210807	Газрын төлбөр	5,885,000.00	5,885,000.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	25,346,467.55	34,460,871.60
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,441,575,868.27	1,507,456,249.24
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	71,717,307.00	139,499,186.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	157,570,480.00	72,483,340.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	1,212,288,081.27	1,295,473,723.24
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	251,470,883.34	251,470,883.34
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		48,470,000
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		48,470,000
2132	Бусад урсгал шилжүүлэг	194,043,047.70	233,873,000.00
